



56

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 33

Номгон

Албан тушаалын сул орон тоонд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэ оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны удирдах албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан Б.Бат-Өлзийг Байгаль орчны газрын даргаар, Ч.Оюунмандахыг Баянговь сумын ИТХ-ын Нарийн бичгийн даргаар тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2. Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.



642460005